| Үндсэн хөрөнгө | 748,329.4 | 733,100.9 | -15,228.5 |
| **Нийт хөрөнгө** | 756,893.1 | 741,301.8 | -15,591.3 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 756,893.1 | 741,301.8 | -15,591.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **756,893.1** | **741,301.8** | **-15,591.3** |

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна: Үүнд:

- Бараа материал данс 362.7 мянган төгрөгөөр буурсан ба 671.8 мянган төгрөгийн үнэт цаасыг үнэ төлбөргүй орлогоор, байгууллагын төсвөөс 26,059.6 мянган төгрөгийг худалдан авалт хийж, нийт 26,731.4 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэж, байгууллагын үйл ажиллагаанд 25,244.2 мянган төгрөгийг зарцуулж, 1,850.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгө данс 15,228.5 мянган төгрөгөөр буурчээ. ТӨБЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарийн 15-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан 5,837.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасч цаашид ашиглах боломжтой 24 ширхэг хөрөнгийг 1,751.3 мянган төгрөгөөр үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоон бүртгэсэн байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан шалтгаан нь тайлант хугацаанд 32,204.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.
- Эздийн өмчийн данс нь 15,591.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зардлыг улсын төсвөөс 560,120.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд тайлант оны эхэнд 610,497.4 мянган төгрөгөөр батлагдсныг 94,902.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 705,399.7 мянган төгрөг болгож тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 705,399.7 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 597,102.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож 108,296.7 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 597,102.9 мянган төгрөг буюу 84.6 хувьтай байгаа нь төсвийг 108,296.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71901-80101 | 648,551.6 | 546,501.9 | 102,049.7 | 84.3% |
| 2 | 71901-80103 | 4,455.0 | 3,480.8 | 974.3 | 78.1% |
| 3 | 71901-80213 | 196.2 | 52.0 | 144.2 | 26.5% |
| 4 | 71901-80224 | 17,885.7 | 14,196.4 | 3,689.3 | 79.4% |
| 5 | 71901-80802 | 27,135.9 | 27,135.9 | 0.0 | 100.0% |
| 6 | 71901-80813 | 1,275.3 | 950.0 | 325.3 | 74.5% |
| 7 | 71901-80820 | 5,900.0 | 4,786.0 | 1,114.0 | 81.1% |
| Нийт | | **705,399.7** | **597,102.9** | **108,296.8** | **84.6%** |

Зардлын хэмнэлтэд 71901-80101 арга хэмжээний цалин хөлс, НДШ-ийн зардал 89,383.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,500.6 мянга, дотоод албан томилолтын зардал 5,496.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын нэгдсэн судалгааны үр дүн:

1. Тус байгууллага нь 108,296.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн боловч Ахмадын тухай хуульд заасан хувь хэмжээгээр ахмадын санд төвлөрүүлэлт хийгээгүй байна.
2. 2024 онд Босго үнээс давсан худалдан авалт хийгээгүй байна.
3. Туслах үйл ажиллагааны 801020 арга хэмжээнээс 52.0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг зарцуулсан бөгөөд зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.
4. Бараа үйлчилгээний бусад зардалд төсөв батлагдаагүй тул зардал гараагүй байна.
5. Тайлант онд 19 орон тоо, 499,679.8 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардал батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 13 орон тоотой ажиллаж 417,826.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд 38,290.3 мянган төгрөгийг төвлөрүүлж зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл 38,221.5 мянга, НДЕГ-аас 68.8 мянга, нийт 38,290.3 мянган төгрөгийн эх үүсвэр бүртгэж цалин хөлс, НДШ-ийн зардалд 36,638.9 мянга, дотоод албан томилолтын зардалд 68.8 мянган төгрөгийг зарцуулж, 1,582.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 599,504.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,992.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг

байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 6,294.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар "Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл", 2022 оны А/89 дүгээр тушаалаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын гэрэл цахилгааны хэрэглээг хэмнэх, албан хэрэг хөтлөлтийг цахим системд шилжүүлэх, өр төлбөрийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар барагдуулах, хууль тогтоомжоор хориглосон аливаа зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажиллажээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттай холбоотойгоор Шилэн дансны цахим хуудсыг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

1.1. Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 13,375.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 1 худалдан авалтын 13,375.0 мянган төгрөгийг гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хууданд мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх ".Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 дэх "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тухай бүр үнэн зөв оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 2,468.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд 1,850.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 426.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 192.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 4 | 19,555.2 | 4 | 19,555.2 | 100% |
| Албан шаардлага | 5 | 5,774.0 | 5 | 5,774.0 | 100% |
| Төлбөрийн акт | 1 | 1,655.6 | 1 | 1,655.6 | 100% |
| **Нийт дүн** | **11** | **166,769.8** | **11** | **166,769.8** | **100%** |

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,544.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил[1] илэрсэн бөгөөд 1,850.0 мянган төгрөгийн 2 алдааг завсрын аудитаар залруулж 426.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 268.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Залруулсан алдаа:

1. Өмнөх аудитаар бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг залруулах зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ тайлант хугацаанд орлого, зардлаар бүртгэсэн байсныг залруулах бичилт хийсэн.
2. Албан хаагчдад олгож буй орон нутгийн нэмэгдлийг тооцож олгохдоо цалингийн тооцооны хүснэгтийг Сангийн сайдын 2017 оны 347-р баталсан журмын дагуу НХМаягт ЦХ 5б-ийн дагуу бодож олгоогүй байсан тул батлагдсан маягтын дагуу гаргуулсан.

**5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны хөнгөлөлтийг 268.0 мянган төгрөгийг давхардуулж олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хянах" , Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Сангийн сайдын 2023 оны 211-р тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар 211105 "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд заасны дагуу ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн зардлын 50 хувийг олгох, өдрийн хоолны хөнгөлөлтийг олгох" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2 дахь "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ:", 2.2.3 дахь "хоолны зардал.", санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Давхардуулж олгосон хоолны хөнгөлөлт 268.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага өгөөгүй.**

**5.3 Зөвлөмж**

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

<u>1.1. Илрүүлэлт</u> Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 426.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтыг тайлант хугацаанд тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.3 дахь "бүх өр төлбөр;", 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Зардлыг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран гарсан цаг хугацаанд нь хүлээн зөвшөөрч аккруэл сууриар бүртгэх, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрч барагдуулахгүй байх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

<u>2.1. Илрүүлэлт</u> Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 9 нэр төрлийн 86 ширхэг, 50,154.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" , Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дахь заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн данснаас хасах, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй үндсэн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Албан хаагчдад олгож буй орон нутгийн нэмэгдлийг тооцож олгохдоо цалингийн тооцооны хүснэгтийг Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар баталсан журмын дагуу НХМаягт ЦХ 5б-ийн дагуу бодож олгоогүй. | 1 | 0 | | | 1 | 0 | 1 | 0 | | | | |
| Өмнөх аудитаар бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг залруулах зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ тайлант хугацаанд орлого, зардлаар бүртгэсэн. | 1 | 1,850.0 | | | 1 | 1,850.0 | 1 | 1,850.0 | | | | |
| **Дүн** | **2** | **1,850.0** | | | **2** | **1,850.0** | **2** | **1,850.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй дотоод албан томилолтыг тайлант хугацаанд тооцож олгосон. | 1 | 426.0 | | | | | 1 | 426.0 | | | | |
| Томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны олговрыг давхардуулж олгосон. | 1 | 268.0 | 1 | 268.0 | | | | | | | | |
| Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 9 нэр төрлийн 86 ширхэг, 50,154.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **3** | **694.0** | **1** | **268.0** | | | **2** | **426.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 13.3 сая төгрөгийн 1 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 1 худалдан авалтын 13.3 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй. | 1 | 26,750.0 | | | 1 | 26,750.0 | | |
| Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **26,750.0** | | | **1** | **26,750.0** | | |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 19 өдөр Дугаар 15/А0860274 Чойр
ТА-2025/38/НА-СТА-ТШЗ

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хүрээнд Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 13.3 сая төгрөгийн 1 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 1 худалдан авалтын 13.3 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх ".Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 дэх "*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*; 6.4.5 дахь "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" гэсэн заалтуудыг тус тус **хэрэгжүүлж ажиллаагүй** байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.*", 4.2.1.11-д "*Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Байгальсайхан, ахлах нягтлан бодогч Ё.Баярмагнай, нягтлан бодогч Ч.Буянхишиг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Г.НАРАНБАЯР

АХЛАХ АУДИТОР Б.ДАРХАНБАТ

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

4227144454
УСА0055 9019049

422504056

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 19 өдөр Дугаар 14/А086 0274 Чойр
ГА-2025/038/НА-СТА-ТИЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Нийгмийн даатгалын газар"-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

✓ Томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны хөнгөлөлт 268.0 мянган төгрөгийг давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6-р тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ:" 2.2.3 дахь "Хоолны зардал" гэсэн заалтуудыг **тус тус зөрчсөн** байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно,*" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "*Төлбөрийн акт тогтоохоход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*", "4.2.3.3-т *"цалин хөлс, шагнал урамшуулал,тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"* гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулж олгосон хоолны хөнгөлөлтийн 268,000.00 (Хоёр зуун жаран найман мянга/ төгрөгийг удирдлага, санхүүгийн ажилтан нар хариуцан барагдуулж, Говьсүмбэр аймгийн Төрийн сан дахь **орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого" 100220000954** тоот дансанд төвлөрүүлэх

42250505

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны дотор өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Байгальсайхан, ахлах нягтлан бодогч Ё.Баярмагнай, нягтлан бодогч Ч.Буянхишиг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Г.НАРАНБАЯР |
| АХЛАХ АУДИТОР | Б.ДАРХАНБАТ |

4217144454
УСА0055 9019049

[1] Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон, Утас:70543179

## ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Аудитын код: ГСА-2025/038/НА-СТА-ТШЗ

Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газар

Аудитын нэр: Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаа: 2024

Тайлант хугацаа: 2024.01.01-2024.12.31

2025.02.13

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /Төгрөгөөр/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **1. Санхүүгийн тайлангийн аудитын алдаа** | | | | | | | | | | |
| 1 | Бараа материал | Бараа материал | Өмнөх аудитаар бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийг залруулах зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ тайлант хугацаанд орлого, зардлаар бүртгэсэн. | 1,850,000 | Залруулга хийх | | | Залруулга хийх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Ахлах нягтлан бодогч нягтлан бодогч | О.Байгальсайхан Ё.Баярмагнай Ч.Буянхишиг |
| 2 | Зардал | Цалингийн зардал | Албан хаагчдад олгож буй орон нутгийн нэмэгдлийг тооцож олгохдоо цалингийн тооцооны хүснэгтийг Сангийн сайдын 2017 оны 347-р батласан журмын дагуу НХМаягт ЦХ 56-ийн дагуу бодож олгоогүй. | | Завсрын аудитаар зөвлөмж өгч залруулсан. | | | Залруулга хийх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Ахлах нягтлан бодогч нягтлан бодогч | О.Байгальсайхан Ё.Баярмагнай Ч.Буянхишиг |
| | | | **Алдааны дүн** | **1,850,000.0** | | | | | | |
| **2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил** | | | | | | | | | | |
| 1 | Нийт өр төлбөр | Өр төлбөр | Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй дотоод албан томилолтыг тайлант хугацаанд тооцож олгосон. | 426,000 | Зөвлөмж өгөх | | | Зөвлөмж өгөх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Ахлах нягтлан бодогч нягтлан бодогч | О.Байгальсайхан Ё.Баярмагнай Ч.Буянхишиг |
| 2 | Нийт зардал | Зардал | Томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны олговрыг давхардуулж олгосон. | 268,000 | Төлбөрийн акт тогтоох | | | Төлбөрийн акт тогтоох | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Ахлах нягтлан бодогч нягтлан бодогч | О.Байгальсайхан Ё.Баярмагнай Ч.Буянхишиг |
| 3 | Нийт зардал | Зардал | Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 9 нэр төрлийн 86 ширхэг, 50,154.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй. | - | Зөвлөмж өгөх | | | Зөвлөмж өгөх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Ахлах нягтлан бодогч нягтлан бодогч | О.Байгальсайхан Ё.Баярмагнай Ч.Буянхишиг |
| | | | **Зөрчлийн дүн** | **694,000.0** | | | | | | |
| **3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл** | | | | | | | | | | |
| 1 | Хууль тогтоомж | Шилэн данс | Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 13.3 сая төгрөгийн 1 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш 1 худалдан авалтын 13.3 сая төгрөгийг гүйлгээг мэдээлээгүй. | 26,750,000 | Албан шаардлага өгөх | | | Албан шаардлага өгөх | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэч Ахлах нягтлан бодогч нягтлан бодогч | О.Байгальсайхан Ё.Баярмагнай Ч.Буянхишиг |
| | | | **Нийцлийн асуудлын дүн** | **26,750,000.00** | | | | | | |
| | | | **Нийт дүн** | **29,294,000.00** | | | | | | |

Бэлтгэсэн: Ахлах аудитор Б.Дарханбат Огноо: 2025.02.13

Хянасан: Аудитын менежер Г.Наранбаяр Огноо: 2025.02.13

Хянасан: Дарга,Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Огноо: 2025.02.13

Танилцаж зөвшөөрсөн:

Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Байгальсайхан Огноо:

Ахлах нягтлан бодогч Ё.Баярмагнай Огноо:

Нягтлан бодогч Ч.Буянхишиг Огноо: